**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 07 сарын 01 өдөр Дугаар А/138 Улаанбаатар хот

Стандартын баримт бичиг батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд "Чанарын менежментийн тогтолцооны стандарт MNS ISO 9001:2015"-ыг нэвтрүүлэхтэй холбогдуулан стандартын шаардлагын дагуу Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны чанарын менежментийн тогтолцооны нэгдсэн зураглалыг 1 дүгээр, дотоод орчны шинжилгээ (4.1)-г 2 дугаар, гадаад орчны шинжилгээ (4.1)-г 3 дугаар, сонирхогч тал, тэдний хэрэгцээ, шаардлага (4.2)-г 4 дүгээр, чанарын бодлого (5.2)-ыг 5 дугаар, чанарын бодлогын 2022 оны зорилт, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (6.2)-г 6 дугаар хавсралт ёсоор тус тус батлахсугай.

2. Энэ тушаалын 1 дүгээр зүйлд заасан гадаад, дотоод орчны шинжилгээгээр илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх талаар санал, төлөвлөгөө гаргаж танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Баярсайхан/-т, Статистик, мэдээллийн технологийн хэлтэс /Н.Нарантуяа/-т тус тус даалгасугай.

3. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд олон улсын "Чанарын менежментийн тогтолцооны стандарт MNS ISO 9001:2015"-ыг иж бүрэн нэвтрүүлэхтэй холбогдуулан чанарын бодлого, бодлогын 2022 оны зорилт, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг яамны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох газар, хэлтсийн дарга нарт, энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Идэрцогт/-т тус тус үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

15?220567

Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны ...07... дугаар сарын..01...ны өдрийн..А/138 дугаар тушаалын ..1.. дугаар хавсралт

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны чанарын менежментийн тогтолцооны нэгдсэн зураглал



Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/138 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (4.1)

БХБЯ-ЧМТ-01-1.2. ISO 9001:2015

| Д/Д | Хүчин зүйлс | Давуу тал | Сул тал |
|---|---|---|---|
| 1. | БОДЛОГО, ЗОРИЛГО, ЗОРИЛТ:<br>• Бодлогын баримт бичигт тусгагдсан болон чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт;<br>• Эрхэм зорилго, үнэт зүйлс, эрхэмлэх зарчим. | 1. Салбарын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө тодорхойлогдсон ба чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтуудаа тодорхойлсон. Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогод зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүнгээ тодорхойлсон. БХБ-ын салбарын үйл ажиллагааны хамрах хүрээ өргөн.<br>2. БХБЯ-ны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөнд алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлсон.<br>**АЛСЫН ХАРАА**<br>Байгаль - нийгэм – эдийн засгийн зохистой шүтэлцээ бүхий хот, суурины тогтвортой хөгжлийг хангах.<br><br>**ЭРХЭМ ЗОРИЛГО** Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, орон сууц, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, инженерийн дэд бүтэц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Эрхэмлэх зарчмаа мөн тодорхойлсон. | 1. Бодлого, зорилго, зорилт, гарах үр дүн, шалгуур үзүүлэлтээ оновчтой тодорхойлох суурь судалгаа, статистик өгөгдлийн мэдээлэл хомс;<br>2. Салбар хоорондын болон засаглалын уялдаа сул;<br>3. Засаглалын бодлого, шийдвэрийн залгамж шинж чанар сул ба тогтвортой, тууштай бус чадварлаг тогтолцоогүй;<br>4. Дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд норм, дүрэм хоцрогдсон ба өнөөгийн дэвшилтэт технологид нийцүүлэн шинэчлэх нэн шаардлагатай.<br>5. БХБЯ Алсын хараа, Эрхэм зорилго, Эрхэмлэх зарчмаа яамны, салбарын үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжүүлэх стратегиа нарийвчлан тодорхойлоогүй ба хэрэгжилт хангалттай бус.<br>6. Ажлын үр дүн урт хугацаанд үр дүнгээ харуулдаг. |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:<br>• Байгууллага газрын бүтэц, зохион байгуулалт;<br>• Салбар, нэгжийн бүтэц, зохион байгуулалт;<br>• Ажлын байрны хуваарилалт, тодорхойлолт. | 1. Яамны бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор батлагдсан /7 газар, 7 хэлтэс, 78 орон тоотой/. Төрийн нарийн бичгийн даргын Б/127 тушаалаар Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, ажил, албан тушаалын жагсаалт, чиг үүргийг шинчлэн баталсан.<br><br>1. Яам үйл ажиллагааны функционал бүтэцтэй тул зөвхөн тухайн нэгж дотроо үр дүнтэй ажиллах давуу талтай бөгөөд яамны үйл ажиллагааны хэрэгжилт удаашралтай, хангалттай бус.<br>2. Нийслэл, 21 аймагт харьяа нэгж бүхий тогтолцоо төлөвшиж, тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг.<br>3. Яам, харьяа байгууллагуудын албан тушаалын тодорхойлолт батлагдсан. | 1. Бүтцийн энэхүү сул талууд болон хэт шатлан захирах ёс нь албан хаагчдын үзэл бодлоо бүрэн илэрхийлэх, асуудал тавих зэрэг зүйлд бүрэн хаалт болдог болон бусад сөрөг нөлөөллүүдийг үзүүлсээр байна.<br>2. Ажлын байр, чиг үүргийн хуваарилалтыг дахин нухацтай авч үзэх шаардлагатай. Учир нь зарим албан хаагчдын ажлын ачаалал их ба зарим нь бага. Тухайлбал: Бодлого, төлөвлөлтийн газрын орон тоо/хүний нөөц хэт цөөхөн.<br>3. Орон тооны цөөн, ажлын хуваарилалт оновчтой бус байдлаас хамаарч төлөвлөгдсөн ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүй байх талтай.<br>4. Хэдийгээр албан тушаалын тодорхойлолт батлагдсан ч түүнд заасан ажлуудаас илүү эсхүл зарим нь дутуу гүйцэтгэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийгээгүй.<br>5. Дээд удирдлагаас гэнэтийн хугацаа давчуу даалгавар орж ирдэг. Энэ нь үндсэн ажил удаашрах болон даалгасан ажил нь хэрэгжихэд нөлөөлдөг. |
| 3. | ДОТООД ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТ, ГЭРЭЭНИЙ ШААРДЛАГУУД:<br>• Байгууллагын дотоод журам, соёл; | 1. Байгууллагын дотоод журмыг баталж, журмын дагуу үйл ажиллагаа явагддаг.<br>2. Байгууллагын соёл нь ажилтан, албан хаагч нарт тогтсон.<br>3. Аливаа үйл ажиллагаа тушаал шийдвэр, захирах, захирагдах ёсны хэм хэмжээнд явагддаг. | 1. Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул.<br>2. Зарим ажлыг хэт шахуу хугацаанд хийдэг.<br>3. Мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй.<br>4. Дотоод журамд өөрчлөлт оруулах шаардлагатай ба байгууллагын соёлын хүрээнд хамт олны уур амьсгал, ажлын байр, |

| | | | |
|---|---|---|---|
| | • Дотоод үйл ажиллагааны хяналтын систем. | 4. Бүх түвшиндээ гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажилладаг. Ажлын төлөвлөгөөг мэргэжилтнээс эхлээд газар, яамны түвшинд хүртэл жил, улирал, сараар төлөвлөн гүйцэтгэлд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг.<br>5. Дотоод сүлжээнд холбогдож мэдээлэл солилцдог.<br>6. Цахим систем нэвтэрсэн. | нийгмийн баталгааг сайжруулах шаардлагатай.<br>5. Байгууллагын соёлын шинэчлэл, ажлын байр, нийгмийн баталгааны талаарх удирдлагын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай. |
| 4. | ХҮНИЙ НӨӨЦ, ТҮҮНИЙ ЧАДАМЖ:<br>• Удирдлагын арга барил, Нөхөн хангалт бүрдэл<br>• Ажиллагсдын мэргэжил, боловсрол, мэдлэг, ур чадвар, хандлага<br>• Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, сургалт, хөгжил. | 1. Хүний нөөцийн нөхөн хангалт тодорхой хэмжээнд хийгдэж мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан.<br>2. Жил бүр гадаад, дотоодод богино хугацааны болон магистр, докторын сургалтад албан хаагчдыг сургаж боловсон хүчнээ мэргэшүүлдэг.<br>3. Салбарын мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтыг тогтмол явуулж, зэрэг олгож, сунгаж байна.<br>4. Байгууллагын талаар иргэдийн ойлголт сайн, мэдээллийн хэрэгслүүдийн олон сувгуудыг ашиглаж өөрсдийн ажлын явц мэдээг таниулдаг.<br>5. Залуу, дунд үе, олон жил ажилласан, туршлагатай албан хаагчдын хосолмол бүтцээр хүний нөөцөө бүрдүүлсэн. Нийт ажилчдын 28% нь 20-35 насных, 31% нь 35-45 насных, 41% нь 45-60 насныхан ажиллаж байна.<br>6. Гадаадын их, дээд сургууль төгссөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчидтай. | 1. Албан хаагчдын ажлын байр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн хөтөлбөр хангалттай түвшинд хэрэгждэггүй. Эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулдаггүй.<br>2. Анх ажилд томилогдсон албан хаагчдад чиглүүлэх сургалт хөтөлбөр явуулдаггүй.<br>3. Төрийн албаны тухай хуулийн дагуу албан тушаалын шатлан дэвших зарчмын хэрэгжилт хангалтгүй.<br>4. Улс төр, танилын нөлөөгөөр тухайн ажлын байрны шаардлагыг хангахгүй иргэн томилогдсноор яамны, салбарын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлдөг, бусдын ажлын гүйцэтгэл, сэтгэл ханамжид дарамт учруулдаг. |
| 5. | АЖЛЫН БАЙРНЫ ОРЧИН НӨХЦӨЛ:<br>• Ажлын байрны тохижилт, нөхцөл, эрүүл ахуй;<br>• Ажлын байрны байршил, хүрэлцээ. | 1. Ажиллах оффисын орчноор хангагдсан.<br>2. Төрийн тусгай хамгаалалтанд байдаг. | 1. Байгууллагын байрлаж буй байр 1961 онд ашиглалтад орж, хуучирсан.<br>2. Ажлын өрөөний зай талбайн норматив шаардлагыг хангахгүй нэг өрөөнд олуулаа сууж ажилладаг. Нэг хүнд ногдох талбайн хэмжээ 6м2, эзлэхүүн нь 20м3-ээс багагүй. Нэг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | цагт нэг хүнд 30м3 агаар, 20…40м3 бол 20 м3 агаар өгөх шаардлагатай гэж стандартад заасан. Гэвч жишээ нь тус яаманд 20м2 талбайд 6-7 хүн сууж ажилладаг.<br>3. Ажлын байрны орчин, дотор агаарын чанар стандартад нийцээгүй.<br>4. Хогоо ангилан ялгаж хаях хогийн сав хүрэлцээ муу, үүдэнд нэг ширхэг байдаг.<br>5. Ажиллах орчин нөхцөл, техник хэрэгслээр бүрэн хангагдаагүй.<br>6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлээгүй. Цахилгаан шатгүй.<br>7. Эрэгтэй эмэгтэй ариун цэврийн хамт байдаг. 1, 3, 4 давхарт.<br>8. Амралтын өрөө болон цайны өрөө байхгүй. Нэг өрөө байгаа боловч сандал ширээний хүрэлцээ сул. Мөн уулзалт зохион байгуулах өрөө хомс.<br>9. Шаардлагатай засвар үйлчилгээ, байнгын сайжруулалт тогтмол хийгддэггүй.<br>10. Байгууллагын автомашины зогсоолгүй, нэгдсэн тээврийн үйлчилгээгүй.<br>11. Галын дохиолол ажилладаггүй.<br>12. 3 байгууллага нэг байранд байрладаг боловч эмч, эмчийн өрөө ажиллуулдаггүй. Анхан шатны эрүүл мэндийн туламж үзүүлэх эм, хэрэгсэл байдаггүй тул эрүүл мэндийн түргэн тусламжийн эрсдэл өндөр. |
| 6. | САНХҮҮГИЙН НӨӨЦ:<br>• Байгууллагын санхүүгийн чадавхи;<br>• Орлогын эх үүсвэр;<br>• Төсвийн хүрэлцээ, захиран зарцуулалт. | 1. Төсвийн хөрөнгө оруулалтын замаар санхүүжилт шийдэгддэг.<br>2. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн шугамаар нэмэлт санхүүжилт шийдэгддэг. | 1. Байгууллагын дотоод орлого байхгүй учраас санхүүгийн чадавх сул;<br>2. Төсөв, зээл тусламжаас хараат;<br>3. Төсөв албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хангалттай бус. |

-------***------

Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны ....07........ дугаар сарын...07...ны өдрийн A/138 дугаар тушаалын ..3... дугаар хавсралт

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ГАДААД МАКРО ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ PESTLE (4.1)

БХБЯ-ЧМТ-01-1.1

| д/д | Хүчин зүйлс | Эерэг нөлөөлөл | Сөрөг нөлөөлөл |
|---|---|---|---|
| | УЛС ТӨРИЙН ОРЧИН:<br>•Сонгуулийн үр дүн<br>•Засгийн газрын болон харьяа байгууллагын бүтэц | 1. Улсын бодлого тодорхойлогдоно.<br>2. Засгийн газрын болон харьяа байгууллагын бүтэц хэрэв оновчтой зохион байгуулагдвал эерэг нөлөө үзүүлдэг.<br>3. Орон тоо, хөрөнгө оруулалт өөрчлөгддөг.<br>4. Зарим хууль, дүрэм, журмуудад нэмэлт өөрчлөлт орох, шинээр дүрэм журмууд батлагддаг. | 1. Төрийн бодлогын залгамж чанар алдагдах, тууштай, тогтвортой бус байдал бий болгох;<br>2. Төрийн захиргааны төв болон төрийн байгууллагуудын бүтэц, орон тооны өөрчлөлтөөс хамаарч хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, төрийн ой санамж, залгамж чанар буурах;<br>3. Албан хаагчдын сэтгэл санаа тогтворгүй болох;<br>4. Нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үүсэх;<br>5. Гадаад харилцаа, худалдаа, хамтын ажиллагаа, түншлэл сулрах;<br>6. Барилгын салбарын бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байхгүй. “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ барилга, хот байгулалтын салбарын норм, стандарт, бодлогын баримт зэрэг зэрэг барим бичгүүдийг гэрээгээр гүйцэтгэдэг. |

| | | | |
|---|---|---|---|
| | ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН:<br>• Улсын төсөв;<br>• Салбарын төсөв;<br>• Олон улсаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэмжээ. | 1. Засгийн газрын үйл ажиллагаатай холбогдуулан нийгэм, эдийн засгийн болон төсвийн санхүүжилтэд өөрчлөлт ордог.<br>2. Салбарын төсөв өөрчлөгдөн нэмэгдэх талтай.<br>3. Тухайн Засгийн газрын болон яамны бодлого, хөтөлбөрөөс хамааран олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт нэмэгдэх, төслүүд хэрэгжих боломж бий болох талтай. | 1. Улсын төсвийн менежмент, мөнгөний бодлого, халамжийн бодлогоос хамаарч инфляцын өсөлт бий болсон.<br>2. Инфляцын өсөлт, хил гаалийн жигд бус ажиллагаа, материал, түүхий эдийн хомсдол, салбарын алсыг харсан менежмент, зохицуулалтгүй зэрэн хүчин зүйлээс хамаарч барилга, барилгын материалын үнийн тогтворгүй байдал, үнийн өсөлт, чанар, аюулгүй байдал алдагдах;<br>3. Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр зогсонги байдалд орох;<br>4. Салбарын хувийн хэвшлийн эдийн засгийн алдагдал, ашиггүй ажиллагаа бий болох.<br>5. Зээлийн эргэн төлөлт шийдэгдээгүй. 360 тэр бум төгрөгийн өрийн үлдэгдэл байна. Ханшийн зөрүү+, усны үнэ доогуур, урсгал алдагдал их.<br>6. Усны үнэ, тариф нэмэх зайлшгүй шаардлагатай. |
| | НИЙГМИЙН ОРЧИН:<br>• Хотжилт, соёлжилт;<br>• Хүн амын өсөлт, насжилт;<br>• Амьжиргааны төвшин<br>• Амьдралын хэв маяг, хандлага. | 1. Шинээр хот төлөвлөж байна. Аймгуудын ерөнхий төлөвлөлтийг боловсруулж байна.<br>2. Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн төсөл 19 аймаг-57 суманд;<br>3. АХБ-ны зээлийн хөрөнгөөр 6 аймагт ус хангамж, цэвэрлэх байгууламжийн төсөл хэрэгжсэн зэрэг байгууламжуудын тоо, хүртээмж нэмэгдэж байна.<br>4. Хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилт, хөдөлгөөн, ажлын байр нэмэгдэх;<br>5. Хот байгуулалт болон нийгэмд чиглэсэн салбарын бодлого хэрэгжиж байгаа.<br>6. Иргэдийн амьдралын эрүүл хэв маяг өөрчлөгдөн бүтээгдэхүүний хэрэглээ, ашиглалт чиглэлд эерэг хандлага, мэдлэгтэй болох. | 1. Салбарын ИТА, ГТА, хүний нөөцийн хомсдолтой. НАА-н салбарын чиглэлээр оюутнууд суралцах сонирхол сул.<br>2. Салбарын хүний нөөцийн бодлого сул, хүний нөөцийг бэлтгэх, томилох залгамж чанар алдагдсан.<br>3. Нийгэм, эдийн засгийн тогтворгүй, тэгш бус байдлаас хамаарч хот хөдөөгийн ялгаа улам ихсэнэ, соёл, сэтгэлгээний ядуурал ихсэнэ.<br>4. Үйлдвэрийн осол гэмтэл, нас баралт их. Хөдөлмөр аюулгүй ажиллагааны<br>5. Амьдралын чанар доройтоно. |

| | | | |
|---|---|---|---|
| | ТЕХНИК ТЕХНОЛОГИ:<br>• Мэдээллийн технологи /программ/;<br>• Орчин үеийн дэвшилтэд техник, технологийн хөгжил;<br>• Судалгаа шинжилгээний үр дүн. | 1. Мэдээллийн технологи, ашиглалт сайжирч байна.<br>2. “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Алсын хараа-2050”-ын хүрээнд Цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.<br>3. Техник, технологийн дэвшлийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр ажилтнуудын ажиллах орчин сайжирна.<br>4. Дотоод ERP ажиллаж байна.<br>5. Хурал, хэлэлцүүлэг, сургалт зэрэг арга хэмжээг цахимаар зохион байгуулснаар цаг хугацаа, зардал хэмнэж байна. | 1. Салбарын шинжлэх ухаан, судалгаа, техник, технологийн хүрээлэнг байгуулж, тогтвортой ажиллуулах шаардлагатай.<br>2. Барилгын норм дүрэм, стандартын нийцэл, хэрэгжилт сул.<br>3. Хүрэн ба бохир технологи ашигласаар байна.<br>4. Салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, технологийн хоцрогдсон байдал болон цахим технологийн дэвшил, ашиглалт хувь хүн, байгууллагын аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх талтай.<br>5. Хурал, уулзалт ажлын хэсгийн хурал болон бусад чиглэлээр цахим орчны ашиглалтыг ажлын цагт байлгах;<br>6. Албан хаагчдын хараа муудсан.<br>7. Бүх төрлийн судалгаа сул.<br>8. Архив, баримт бичгийн аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай.<br>9. Нөөцийн сервер. |
| | ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН:<br>• Хууль, тогтоомж<br>• Бодлого, хөтөлбөр | 1. Хууль эрх зүйн орчин боловсронгүй болсоор байна.<br>2. Нийгэм, эдийн засагт чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд оновчтой. | 1. Хууль эрх зүйн хэрэгжилт сул;<br>2. Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт саатах, зогсонги байдалд орох;<br>3. Шинэчлэл, өөрчлөлтийн чилэлд улс төр, удирдлагын дэмжлэг сул;<br>4. Ногоон барилга, хот байгуулалтын үнэлгээний систем, норм дүрэм байхгүй;<br>5. Газар хөдлөлт, бат бэхтэй холбоотой норм дүрмийн хэрэгжилт сул;<br>6. Барилга байгууламжийн зураг төслөөс эхлээд барих, ашиглалтад өгөх хүртэл алдаа гардаг;<br>7. Газар хөдлөлтийн идэвхжил барилга, хот байгуулалт, хүний аюулгүй байдалд аюул учруулах талтай;<br>8. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжийг хүчитгэх, буулгах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай ба хөрөнгө оруулалт төсөвлөдөггүй;<br>9. Инженерчлэл, техник, технологийн хөгжил сул;<br>10. БХБЯ-ны барилгыг шинээр ойрын хугацаанд барих шаардлагатай. |

| | | | |
|---|---|---|---|
| | **ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН** /НУТАГ ДЭВСГЭРИЙН БОЛОН САЛБАРЫН ОРЧИН/<br>• Орон нутгийн бүс нутаг уур амьсгалын онцлог | 1. Парисын хэлэлцээр хэрэгжиж байгаа.<br>2. Барилгын салбарын нүүрс хүчлийн хийг тодорхойлох, салбарыг ногоон болгох нэгдсэн ойлголтод хүрсэн.<br>3. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.<br>4. Ажрахгүй /Resilient/ хотыг бий болгох нэгдсэн ойлголт бүрдэж байгаа.<br>5. Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, барилга байгууламжийн бат бэхийн талаар норм, дүрмүүд батлагдсан, хэрэгжиж байна. | 1. Газар хөдлөлтийн идэвхитэй бүс нутагт байрладаг.<br>2. Уур амьсгалын өөрчлөлт хурдацтай явагдаж байгаа.<br>3. Барилга байгууламжийн геотехник, геодезийн судалгааг бүрэн хийж, ашиглаж байх шаардлагатай.<br>4. Хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөлд уур амьсгал, байгаль цаг уурын өөрчлөлт, онцлогийг норм дүрмийн дагуу тусгах байх шаардлагатай. |

-------***-------

Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны ...07......... дугаар сарын..01...ны өдрийн А/38. дугаар тушаалын 4... дугаар хавсралт

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
СОНИРХОГЧ ТАЛ, ТЭДНИЙ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА (4.2)

БХБЯ-ЧМТ-01-1.3 ISO 9001:2015

| Сонирхогч тал | Төрөл | Сонирхогч талын хэрэгцээ, шаардлага | Шаардлагыг тогтоосон баримт бичиг, хууль тогтоомж | Нийцлийн талаарх тайлбар / үр дүн/ |
|---|---|---|---|---|
| Улсын Их Хурал | Гадаад | 1. Зөв, оновчтой бодлого, төлөвлөлт, хууль эрх зүй<br>2. Менежмент, гүйцэтгэл | 1. УИХ-ын тогтоол<br>2. Салбарын болон бусад хууль тогтоомж | |
| Засгийн газар | Гадаад | 1. Зөв бодлого, төлөвлөлт<br>2. Менежмент, гүйцэтгэл | 1. ЗГ-ын тогтоол, үйл ажиллгааны хөтөлбөр, үндсэн чиглэл<br>2. Тайлангууд | 1. Төлөвлөгөө<br>2. Тайлан, биелэлт<br>3. Үнэлгээ<br>4. Санал, зөвлөмж, чиглэл, тогтоол |
| Төрийн аудит | Гадаад | 1. Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдсөн байдал<br>2. Үр дүн | 1. Төсвийн тухай хууль,<br>2. Тендерийн тухай хууль тогтоомж<br>3. Төрийн албаны тухай хууль, дүрэм журмууд;<br>4. Төрийн албаны зөвлөлийн тогтоол. | 1. Аудитын дүгнэлт<br>2. Төлөвлөгөө<br>3. Биелэлт |
| Төрийн албаны зөвлөл | Гадаад | 1. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт, | 1. Төрийн албаны тухай хууль, дүрэм журам,<br>2. Хөдөлмөрийн тухай хууль; | 1. Албан тушаалын тодорхойлолтыг зөвшилцөж батлах, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2. Хүний нөөцийн чадваржуулах<br>3. Орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх | 3. Төрийн албаны зөвлөлийн тогтоол<br>4. Тайлан, мэдээлэл, судалгаа | 2. Хүний нөөцийг бүрдүүлэх /сонгон шалгаруулалт/, төлөвлөх, чадавхжуулах, хадгалах.<br>3. Зөвлөмж, чиглэл |
| Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | Дотоод | 1.Зөв бодлого, төлөвлөлт<br>2. Менежмент, гүйцэтгэл | 1. Салбарын хууль тогтоомж, тушаал, шийдвэр;<br>2. Салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл<br>3. Тайлангууд | 1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тушаал, шийдврийн төсөл,<br>2. Төлөвлөгөө<br>3. Тайлан<br>4. Санал, зөвлөмж, чиглэл, албан бичиг |
| "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ | Гадаад | Төлөвлөгөө батлуулах, гэрээ байгуулах, бодлого, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | 1. ЗГ-ын 2017 оны 51 дүгээр тогтоол | 1. Төлөвлөгөө<br>2. Гэрээ<br>3. Тайлан<br>4. Тушаал, шийдвэр, зөвлөмж, албан даалгавар, чиглэл, албан бичиг |
| "Төрийн орон сууцны кропораци" ТӨХХК | Гадаад | Төлөвлөгөө батлуулах, гэрээ байгуулах, бодлого, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | 1. ЗГ-ын 2017 оны 51 дүгээр тогтоол | 1. Төлөвлөгөө<br>2. Гэрээ<br>3. Тайлан,<br>4. Тушаал, шийдвэр, зөвлөмж, албан даалгавар, чиглэл, албан бичиг |
| "Монголын барилгачдын нэгдсэн холбоо" ТББ | Гадаад | Хэрэгжүүлэх ажлын зохицуулалтыг боловсронгуй болгох. | Барилгын тухай хууль, БХБ-н сайдын 2017 оны 200 дугаар тушаал, дүрэм | 1. Гэрээ;<br>2. Үйл ажиллагааны төлөвлөгөө;<br>3. Төлөвлөгөөний биелэлт;<br>4. Тушаал, дүрэм, зөвлөмж, чиглэл, санал, албан бичиг |
| "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ | Гадаад | Хэрэгжүүлэх ажлын зохицуулалтыг боловсронгуй болгох | Барилгын тухай хууль, БХБ-н сайдын 2017 оны 200 дугаар тушаал, дүрэм | 1. Гэрээ;<br>2. Үйл ажиллагааны төлөвлөгөө;<br>3. Төлөвлөгөөний биелэлт;<br>4. Тушаал, дүрэм, зөвлөмж, чиглэл, санал, албан бичиг. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Аймаг, нийслэлийн Засаг дарга нар | Гадаад | Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тухай гэрээ | Засгийн газрын тухай хууль | 1.Гэрээ;<br>2.Үйл ажиллагааны төлөвлөгөө;<br>3.Төлөвлөгөөний биелэлт;<br>4. Тушаал, дүрэм, зөвлөмж, чиглэл, санал, албан бичиг. |
| Аймаг, нийслэл дэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрууд | Гадаад | Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тухай гэрээ | Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж | 1. Гэрээ;<br>2. Үйл ажиллагааны төлөвлөгөө;<br>3. Төлөвлөгөөний биелэлт;<br>4. Тушаал, дүрэм, зөвлөмж, чиглэл, санал, албан бичиг. |
| Удирдлагын академийн Төрийн албаны сургууль | Гадаад | Хүний нөөцийн чадавхийг сайжруулах | Төрийн албаны тухай хууль, дүрэм, журам | 1. Төлөвлөгөө<br>2. Тайлан |
| Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд | Гадаад | Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, техникийн туслалцаа авах | 1. Олон улсын гэрээ хэлэлцээр;<br>2. БХБЯ-ны гадаад томилолтын журам | 1. Санамж бичиг<br>2. Гэрээ байгуулах<br>3. Гэрээний биелэлт<br>4. Хамтын ажиллагааны лавлах; |
| Олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд | Гадаад | Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, техникийн туслалцаа авах | 1. Олон улсын гэрээ хэлэлцээр | 1. Санамж бичиг<br>2. Гэрээ байгуулах<br>3. Гэрээний биелэлт<br>4. Хамтын ажиллагааны лавлах. |
| Төслийн нэгжүүд | Гадаад | Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | 1. Удирдлагаар хангах, хүний нөөц, ажиллах хүчнээр хангаж үйл ажиллагаа явуулах нөхцөл<br>2. Төсөв, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх | 1. Гэрээ байгуулах;<br>3. Гэрээ, төлөвлөгөөбиелэлт, тайлан;<br>4. Санал, зөвлөмж, тушаал, шийдвэр, албан бичиг. |
| Салбарын аж ахуйн нэгж байгууллагууд | Гадаад | Шаардлагад нийцсэн бодлого, дүрэм, журам | 1. Барилгын тухай хууль<br>2. Хуулийг дагалдаж гарах дүрэм журам | Нэгдсэн стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байгааг илэрхийлэх тоон мэдээлэл, статистик үр дүн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Иргэд | Гадаад | Шаардлагад нийцсэн бодлого, дүрэм, журам | 1. Ашиглалтад орж буй байр, орон сууцны мэдээлэл, нэгдсэн мэдээлэл<br>2. Түрээсийн байр түүнд хамрагдах журмууд | Төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдал /Иргэдийн сэтгэл ханамж/ |

------***-----

Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны ....07. дугаар сарын..01...ны өдрийн...А/138 дугаар тушаалын .05.. дугаар хавсралт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ЧАНАРЫН БОДЛОГО (5.2)

БХБЯ-ЧМТ-05 ISO 9001:2015

АЛСЫН ХАРАА

Байгаль - нийгэм – эдийн засгийн зохистой шүтэлцээ бүхий хот, суурины тогтвортой хөгжлийг хангах.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, орон сууц, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, инженерийн дэд бүтэц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

ЧАНАРЫН БОДЛОГО

Барилга, хот байгуулалтын яам нь чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулан мэргэшсэн, чадварлаг хүний нөөц, оновчтой бүтэц, зохион байгуулалттайгаар шинжлэх ухаан, судалгаа, шинжилгээнд суурилсан салбарын бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангана.

Барилга, хот байгуулалтын яам нь Чанарын бодлогыг үйл ажиллагаандаа 2022 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн баримталж, бодлогын зорилтын арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

----***----

Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/138 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ЧАНАРЫН ЗОРИЛТ (6.2)

БХБЯ-ЧМТ-06 ISO 9001:2015

Барилга, хот байгуулалтын яамны Чанарын бодлогын хүрээнд 2022 онд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллахад яамны удирдлага тууштай манлайлагч байхаа харуулах, үүрэг, амлалтаа биелүүлэх;
2. Ажлын байрны зохион байгуулалтын 5S стандартыг яаманд нэвтрүүлэн өрөөний эмц цэгц, хүртээмж, зохион байгуулалтыг сайжруулах.
3. Яамны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, хүнийг чадамжид нь суурилан хөгжүүлэх.
4. Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO: 9001-2015 стандартын шаардлагыг хангасан байх “Гэрчилгээ”-г яам авах;
5. Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухаан, судалгаа, техник технологийн институт /хүрээлэн, төв/-ийг байгуулах судалгаа хийж, холбогдох арга хэмжээг авах.

Эдгээр зорилтуудыг 2022 оны 2 дугаар хагас жилийн төлөвлөгөөнд холбогдох албан хаагчид тусган хэрэгжилтийг зохион байгуулна.

-----***----

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
## ЧАНАРЫН БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
## БХБЯ-ЧМТ-01-1.1 ISO 9001:2015

| Чанарын зорилт | Үйл ажиллагаа | Төсөв мянган төгрөгөөр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Чанарын бодлого:** Барилга, хот байгуулалтын яам нь чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулан мэргэшсэн, чадварлаг хүний нөөц, оновчтой бүтэц, зохион байгуулалттайгаар шинжлэх ухаан, судалгаа, шинжилгээнд суурилсан салбарын бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангана. | | | | | | | |
| 1. Чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллахад яамны удирдлага тууштай манлайлагч байхаа харуулах, үүрэг, амлалтаа биелүүлэх. | 1.1.Яамны удирдлага нь хууль тогтоомжийн дагуу яамны болон салбарын өдөр тутмын ажил үүргийг өөрийн биеэр үлгэрлэн манлайлж хэрэгжүүлэх; | - | Аудитын байгууллагын үнэлгээ, баталгаажуулалт. Яамны удирдлагуудын манлайллын талаарх албан хаагчдын үнэлгээ. | Яамны үйл ажиллагаа нь MNS ISO 9001:2016 стандартын шаардлагын нийцэл 32%-тай байна. | Аудитын байгууллагын үнэлгээ 65-аас дээш хувь. | II-IV улирал | С.Магнайсүрэн<br>Б.Гүнболд<br>Д.Баярсайхан |
| | 1.2.Яамны үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хянах шалгах, сайжруулах зэрэг процессыг удирдлага, зохицуулалтаар бүрэн хангаж, тасралтгүй сайжруулалтыг хэрэгжүүлэх; | - | Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, шалгалт, сайжруулалтын процессыг удирдан зохион байгуулсан арга хэмжээний тоо, чанар, үр дүн. | Яамны зөвхөн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд үнэлгээ өгч ирсэн. | Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, шалгалт, сайжруулалтын процессд үнэлгээ хийдэг болсон байх. Сайжруулалтын үр дүнг тооцно. | II-IV улирал | С.Магнайсүрэн<br>Б.Гүнболд<br>Д.Баярсайхан |
| | 1.3.Чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулахад бүх албан хаагчдын идэвхи, оролцоог манлайлах. | - | 80 ба түүнээс дээш хувь. | Чанарын менежментийн багийн 15 албан хаагчдаас 9 нь идэвхитэй ажиллаж ирсэн. | Удирдлага, албан хаагчдын 80% - иас доошгүй оролцоог хангана. | II-IV улирал | С.Магнайсүрэн<br>Б.Гүнболд<br>Д.Баярсайхан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Ажлын байрны зохион байгуулалтын 5S стандартыг яаманд нэвтрүүлэн өрөөний эмц цэгц, хүртээмж, зохион байгуулалтыг сайжруулах. | 2.1. 5S стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, үнэлгээ хийлгэх; | 350.0 | 5S стандартыг нэвтрүүлж, дундаж үнэлгээ 4.0-ээс доошгүй байх. | Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа "зарим өрөөний хүртээмж сул, дотор агаарын чанар эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж байна" гэж харуулсан. 14 албан хаагчид 5S стандарт нэвтрүүлэлтэд оролцож, үнэлүүлсэн. Дундаж үнэлгээ 2.9 оноо. | Яамны хэмжээнд 5S стандартыг нэвтрүүлэн дундаж үнэлгээг 4.0 хүргэнэ. Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалт сайжирна. | II-IV улирал | Д.Баярсайхан А.Лхамсэржид Зөвлөх үйлчилгээ |
| | 2.2. Өрөөг оновчтой хуваарилан хүртээмж, зохион байгуулалтыг сайжруулах. | Улсын төсөв, бусад эх үүсвэр | ББМҮБХЗГ, ХБГХБХЗГ, СХОГ-ын гүйцэтгэх албан тушаалтнуудын өрөөний талбайн хэмжээг MNS5027-2001 стандартын шаардлагад нийцүүлсэн байх. /1 хүнд ногдох талбайн хэмжээ 6мкв, эзэлхүүн 2кубм-ээс доошгүй байх./ | | ББМҮБХЗГ, ХБГХБХЗГ, СХОГ-ын гүйцэтгэх албан тушаалтнуудын өрөөний талбайн хэмжээг MNS5027-2001 стандартын шаардлагад нийцүүлнэ. | II-IV улирал | Д.Баярсайхан |
| 3.Яамны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, хүнийг чадамжид нь суурилан хөгжүүлэх. | 3.1. Стандарт нэвтрүүлэхтэй холбоотой журам, яамны эрсдэл, үйл явцын зураглал болон хууль тогтоомж, бусад баримт бичгийн жагсаалтыг гаргаж ТНБД-аар батлуулах болон бусад ажлуудыг хэрэгжүүлэх; | - | Журам-6, Үйл явцын зураглал-1, Баримт бичгийн жагсаалт-1, Албан хаагчдын чадамжийн үнэлгээ-1, Сургалт хөгжлийн төлөвлөгөө-1. | ТНБД-ын 2022.6.7-ны А/129 дүгээр тушаалаар журам боловсруулах Ажлын хэсэг байгуулсан. Үйл явцын зураглалыг эхлүүлсэн. | Журам-6, Үйл явцын зураглал-1, Баримт бичгийн жагсаалт-1, Албан хаагчдын чадамжийн үнэлгээ-1, Сургалт хөгжлийн төлөвлөгөө-1. | II-IV улирал | Б.Гүнболд Д.Баярсайхан Л.Идэрцогт Н.Нарантуяа Б.Нямдорж |
| | 3.2.Яамны албан хаагчдын чадамжийн үнэлгээ хийх; | Зөвлөх үйлчил-гээ | Үнэлгээ -70% | - | Үнэлгээ -70% ба түүнээс дээш. | II-IV улирал | Д.Баярсайхан Зөвлөх үйлчилгээ |
| | 3.3. Салбарын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг дахин боловсруулж | - | Биелэлт -100% | Эхний хагас жилийн байдлаар яамнаас зохион байгуулсан | Биелэлт -100% | II-III улирал | А.Лхамсэржид |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах, хэрэгжилтийг зохисн байгуулах. | | | сургалтад 145 албан хаагчдыг хамруулсан. | | | |
| 4. Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO: 9001-2015 стандартын шаардлагыг хангасан байх "Гэрчилгээ"-г яам авах. | 4.1. Яамны Алсын хараа. Эрхэм зорилго, Чанарын бодлого, бодлогын зорилтыг самбар, вебсайтаар нийтэд ил тод болгон мэдээлэх ажлыг зохион байгуулах. | 300.0 | Самбар, вэбсайтаар нийтэд ил тод байршуулсан байх. | Яамны Алсын хараа, Эрхэм зорилго стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан. | Самбар, вэбсайтаар нийтэд ил тод байршуулна. | II улирал | Б.Биндэръяа<br>Ч.Амартүвшин<br>Чанарын баг |
| | 4.2.Аудитын сургалтад албан хаагчдыг хамруулах; | Зөвлөх үйлчил-гээ | Албан хаагчдын тоо, Гэрчилгээний тоо. | Албан хаагчид энэ чиглэлийн сургалтад хамрагдаагүй. | 15-аас доошгүй албан хаагчид. | II улирал | А.Лхамсэржид |
| | 4.3. Аудитороор үнэлгээ хийлгэх. | 450.0 | Үнэлгээ-65% ба түүнээс дээш | Яамны үйл ажиллагаа нь MNS ISO 9001:2015 стандартын шаардлагын нийцэл **32%**-тай байна. | 65% ба түүнээс дээш. | II-IV улирал | Д.Баярсайхан<br>Зөвлөх үйлчилгээ |
| 5. Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж салбарын төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухаан, судалгаа, техник технологийн институт /хүрээлэн, төв/-ийг байгуулах судалгаа хийж, холбогдох арга хэмжээг авах. | 5.1.Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын төрийн захиргааны байгууллагыг байгуулах суурь судалгааг хийж, удирдлагад танилцуулах. | 5.000,0 | Судалгаа -1, шийдвэр-1 | Чиг үүргийн шинжилгээ хийгдсэн. | Эрсдлийн шинжилгээ-1, судалгаа-1. шийдвэр-1. | II-IV улирал | Д.Гантулга<br>Н.Нарантуяа |
| | 5.2. Салбарын шинжлэх ухаан, судалгаа, техник технологийн институт /хүрээлэн, төв/-ийг байгуулах судалгаа хийж, удирдлагад танилцуулах. | 5.000,0 | Судалгаа -1, шийдвэр-1 | - | Эрсдлийн шинжилгээ-1, судалгаа-1, шийдвэр-1. | II-IV улирал | Д.Гантулга<br>Н.Нарантуяа |

----***----

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ЧАНАРЫН БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
БХБЯ-ЧМТ-01-1.1 ISO 9001:2015

| Чанарын зорилт | Үйл ажиллагаа | Төсөв мянган төгрөгөөр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Чанарын бодлого:** Барилга, хот байгуулалтын яам нь чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулан мэргэшсэн, чадварлаг хүний нөөц, оновчтой бүтэц, зохион байгуулалттайгаар шинжлэх ухаан, судалгаа, шинжилгээнд суурилсан салбарын бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангана. | | | | | | | |
| 1. Чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллахад яамны удирдлага тууштай манлайлагч байхаа харуулах, үүрэг, амлалтаа биелүүлэх. | 1.1.Яамны удирдлага нь хууль тогтоомжийн дагуу яамны болон салбарын өдөр тутмын ажил үүргийг өөрийн биеэр үлгэрлэн манлайлж хэрэгжүүлэх; | - | Аудитын байгууллагын үнэлгээ, баталгаажуулалт. Яамны удирдлагуудын манлайллын талаарх албан хаагчдын үнэлгээ. | Яамны үйл ажиллагаа нь MNS ISO 9001:2016 стандартын шаардлагын нийцэл 32%-тай байна. | Аудитын байгууллагын үнэлгээ 65-аас дээш хувь. | II-IV улирал | С.Магнайсүрэн<br>Б.Гүнболд<br>Д.Баярсайхан |
| | 1.2.Яамны үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хянах шалгах, сайжруулах зэрэг процессыг удирдлага, зохицуулалтаар бүрэн хангаж, тасралтгүй сайжруулалтыг хэрэгжүүлэх; | - | Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, шалгалт, сайжруулалтын процессыг удирдан зохион байгуулсан арга хэмжээний тоо, чанар, үр дүн. | Яамны зөвхөн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд үнэлгээ өгч ирсэн. | Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, шалгалт, сайжруулалтын процессд үнэлгээ хийдэг болсон байх. Сайжруулалтын үр дүнг тооцно. | I-IV улирал | С.Магнайсүрэн<br>Б.Гүнболд<br>Д.Баярсайхан |
| | 1.3.Чанарын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулахад бүх албан хаагчдын идэвхи, оролцоог манлайлах. | - | 80 ба түүнээс дээш хувь. | Чанарын менежментийн багийн 15 албан хаагчдаас 9 нь идэвхитэй ажиллаж ирсэн. | Удирдлага, албан хаагчдын 80% -иас доошгүй оролцоог хангана. | II-IV улирал | С.Магнайсүрэн<br>Б.Гүнболд<br>Д.Баярсайхан |
| | 1.4. Яамны гадаад, дотоод орчны шинжилгээ /PESTLE, SWOT/-ээр илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх талаар | - | Шинжилгээнд тусгагдсан сул талуудыг шийдвэрлэх талаарх санал, төлөвлөгөө, | - | Шинжилгээнд тусгагдсан сул талуудыг шийдвэрлэх талаарх санал, | II-IV улирал | Д.Баярсайхан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санал, төлөвлөгөө гаргаж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | | төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 60-аас доошгүй. | | |
| 2. Ажлын байрны зохион байгуулалтын 5S стандартыг яаманд нэвтрүүлэн өрөөний эмц цэгц, хүртээмж, зохион байгуулалтыг сайжруулах. | 2.1. 5S стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, үнэлгээ хийлгэх; | 350.0 | 5S стандартыг нэвтрүүлж, дундаж үнэлгээ 4.0-ээс доошгүй байх. | Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа "зарим өрөөний хүртээмж сул, дотор агаарын чанар эрүүл ахуйн шаардлага хангахгүй, ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж байна" гэж харуулсан. 14 албан хаагчид 5S стандарт нэвтрүүлэлтэд оролцож, үнэлүүлсэн. Дундаж үнэлгээ 2.9 оноо. | Яамны хэмжээнд 5S стандартыг нэвтрүүлэн дундаж үнэлгээг 4.0 хүргэнэ. Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалт сайжирна. | II-IV улирал | Д.Баярсайхан А.Лхамсэнжид Зөвлөх үйлчилгээ |
| | 2.2. Өрөөг оновчтой хуваарилан хүртээмж, зохион байгуулалтыг сайжруулах. | Улсын төсөв, бусад эх үүсвэр | ББМҮБХЗГ, ХБГХБХЗГ, СХОГ-ын гүйцэтгэх албан тушаалтнуудын өрөөний талбайн хэмжээг MNS5027-2001 стандартын шаардлагад нийцүүлсэн байх. /1 хүнд ногдох талбайн хэмжээ 6мкв, эзэлхүүн 2кубм-ээс доошгүй байх./ | | ББМҮБХЗГ, ХБГХБХЗГ, СХОГ-ын гүйцэтгэх албан тушаалтнуудын өрөөний талбайн хэмжээг MNS5027-2001 стандартын шаардлагад нийцүүлнэ. | II-IV улирал | Д.Баярсайхан |
| 3.Яамны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, хүнийг чадамжид нь суурилан хөгжүүлэх. | 3.1. Стандарт нэвтрүүлэхтэй холбоотой журам, яамны эрсдэл, үйл явцын зураглал болон хууль тогтоомж, бусад баримт бичгийн жагсаалтыг гаргаж ТНБД-аар батлуулах болон бусад ажлуудыг хэрэгжүүлэх; | - | Журам-6, Үйл явцын зураглал-1, Баримт бичгийн жагсаалт-1, Албан хаагчдын чадамжийн үнэлгээ-1, Сургалт хөгжлийн төлөвлөгөө-1. | ТНБД-ын 2022.6.7-ны А/129 дүгээр тушаалаар журам боловсруулах Ажлын хэсэг байгуулсан. Үйл явцын зураглалыг эхлүүлсэн. | Журам-6, Үйл явцын зураглал-1, Баримт бичгийн жагсаалт-1, Албан хаагчдын чадамжийн үнэлгээ-1, Сургалт хөгжлийн төлөвлөгөө-1. | II-IV улирал | Б.Гүнболд Д.Баярсайхан Л.Идэрцогт Н.Наранчуяа Б.Нямдорж |
| | 3.2.Яамны албан хаагчдын чадамжийн үнэлгээ хийх; | Зөвлөх үйлчил-гээ | Үнэлгээ -70% | - | Үнэлгээ -70% ба түүнээс дээш. | II-IV улирал | Д.Баярсайхан Зөвлөх үйлчилгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.3. Салбарын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг дахин боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах. | - | Биелэлт -100% | Эхний хагас жилийн байдлаар яамнаас зохион байгуулсан сургалтад 145 албан хаагчдыг хамруулсан. | Биелэлт -100% | II-III улирал | А.Лхамсэржид |
| 4. Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO: 9001-2015 стандартын шаардлагыг хангасан байх "Гэрчилгээ"-г яам авах. | 4.1. Яамны Алсын хараа, Эрхэм зорилго, Чанарын бодлого, бодлогын зорилтыг самбар, вебсайтаар нийтэд ил тод болгон мэдээлэх ажлыг зохион байгуулах. | 300.0 | Самбар, вэбсайтаар нийтэд ил тод байршуулсан байх. | Яамны Алсын хараа, Эрхэм зорилго стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан. | Самбар, вэбсайтаар нийтэд ил тод байршуулна. | II улирал | Б.Биндэръяа Ч.Амартүвшин Чанарын баг |
| | 4.2.Аудитын сургалтад албан хаагчдыг хамруулах; | Зөвлөх үйлчил-гээ | Албан хаагчдын тоо, Гэрчилгээний тоо. | Албан хаагчид энэ чиглэлийн сургалтад хамрагдаагүй. | 15-аас доошгүй албан хаагчид. | II улирал | А.Лхамсэржид |
| | 4.3. Аудитороор үнэлгээ хийлгэх. | 450.0 | Үнэлгээ-65% ба түүнээс дээш | Яамны үйл ажиллагаа нь MNS ISO 9001:2015 стандартын шаардлагын нийцэл **32%**-тай байна. | 65% ба түүнээс дээш. | II-IV улирал | Д.Баярсайхан Зөвлөх үйлчилгээ |
| 5. Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж салбарын төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухаан, судалгаа, техник технологийн институт /хүрээлэн, төв/-ийг байгуулах судалгаа хийж, холбогдох арга хэмжээг авах. | 5.1.Барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын төрийн захиргааны байгууллагыг байгуулах суурь судалгааг хийж, удирдлагад танилцуулах. | 5.000,0 | Судалгаа -1, шийдвэр-1 | Чиг үүргийн шинжилгээ хийгдсэн. | Эрсдлийн шинжилгээ-1, судалгаа-1. шийдвэр-1. | II-IV улирал | Д.Гантулга Н.Нарантуяа |
| | 5.2. Салбарын шинжлэх ухаан, судалгаа, техник технологийн институт /хүрээлэн, төв/-ийг байгуулах судалгаа хийж, удирдлагад танилцуулах. | 5.000,0 | Судалгаа -1, шийдвэр-1 | - | Эрсдлийн шинжилгээ-1, судалгаа-1, шийдвэр-1. | II-IV улирал | Д.Гантулга Н.Нарантуяа |

----***----